

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/326/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл.....
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/140
танай _____ -ны № _____ -т

Г ТӨВ АЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ,
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА
Э.ГЭРЭЛТЦОГТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөх татан буугдах нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзлээ.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 2 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 95,0 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,045,646,850.79	1,088,146,063.19
27	АВЛАГА	(0.00)	5,000.00
34	Бусад авлага	(0.00)	5,000.00
35	Байгууллагаас авах авлага	(0.00)	5,000.00
60	БАРАА МАТЕРИАЛ	1,045,646,850.79	1,088,141,063.19
61	Түүхий эд материал	1,007,690,744.68	1,040,005,267.01
62	Тусгай зориулалттай материал	1,007,690,744.68	1,040,005,267.01
66	Хангамжийн материал	37,956,106.11	48,135,796.18
67	Бичиг хэргийн материал	1,621,235.10	1,907,204.42
68	Аж ахуйн материал	3,240,266.00	3,522,216.00
69	Сэлбэг хэрэгсэл	10,841,813.20	10,841,813.20
70	Түлш шатах тослох материал	1,911,250.00	171,262.00
73	Бусад хангамжийн материал	20,341,541.81	31,693,300.56
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,298,755,873.37	1,276,420,715.28
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,298,755,873.37	1,276,420,715.28
108	Биет хөрөнгө	289,770,373.44	267,536,965.40
109	Барилга, байгууламж	188,661,916.80	189,981,916.80
110	Хуримтлагдсан элэгдэл	(39,370,201.92)	(51,355,609.56)
111	Авто тээврийн хэрэгсэл	56,267,573.78	56,267,573.78
112	Хуримтлагдсан элэгдэл	(16,880,272.20)	(22,507,029.60)
113	Машин, тоног төхөөрөмж	119,307,479.44	120,186,487.01
114	Хуримтлагдсан элэгдэл	(61,559,251.81)	(66,873,147.85)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,243,040.00	13,061,800.00
116	Хуримтлагдсан элэгдэл	(6,476,741.98)	(6,229,412.48)
122	Бусад үндсэн хөрөнгө	75,482,388.49	73,970,850.00
123	Хуримтлагдсан элэгдэл	(35,905,557.16)	(38,966,462.70)
126	Биет бус хөрөнгө	1,008,985,499.93	1,008,883,749.88
127	Програм хангамж	1,430,000.00	1,430,000.00
128	Хасагдуулга	(797,500.07)	(899,250.12)
131	Газар эзэмших эрх	1,008,353,000.00	1,008,353,000.00
139	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,344,402,724.16	2,364,566,778.47
216	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,344,402,724.16	2,364,566,778.47
217	Засгийн газрын хувь оролцоо	2,344,402,724.16	2,364,566,778.47
218	Засгийн газрын оруулсан капитал /ЗГС	1,343,813,362.55	1,343,813,362.55
219	Өмч: -Төрийн өмч	1,343,813,362.55	1,343,813,362.55
225	Хуримтлагдсан үр дүн	972,869,907.39	993,033,961.70
226	Өмнөх үеийн үр дүн	972,869,907.39	972,869,907.39
227	Тайлант үеийн үр дүн	-	20,164,054.31
229	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,719,454.22	27,719,454.22
233	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ	2,344,402,724.16	2,364,566,778.47

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,562,524,518.40	2,751,932,568.77
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,446,936.40	61,771,850.77
77	Нийтлэг татварын бус орлого	73,446,936.40	61,771,850.77
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	73,446,936.40	61,771,850.77
83	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,000.00	1,242,600.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	73,326,936.40	60,529,250.77
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,489,077,582.00	2,690,160,718.00
111	Улсын төвлөрсөн төсвөөс	1,481,559,800.00	2,687,466,818.00
112	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,481,559,800.00	2,687,466,818.00
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,517,782.00	2,693,900.00
125	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	4,679,032.00	-
126	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээ	2,838,750.00	2,693,900.00
146	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,573,627,726.68	2,731,768,514.46
147	УРСГАЛ ЗАРДАЛ	1,482,956,723.93	2,272,665,112.56
148	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,482,956,723.93	2,272,665,112.56
149	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,183,306,015.61	1,862,519,145.47
150	Цалин	877,982,500.00	1,136,844,217.62
151	Нэмэгдэл цалин	274,110,000.00	464,453,827.85
152	Унаа хоолны хөнгөлөлт	31,213,515.61	112,847,000.00
153	Урамшуулал	-	148,374,100.00
156	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,913,600.00	235,107,733.53
157	Тэтгэврийн даатгалын шимтгэл	100,581,200.00	161,229,542.63
158	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	11,833,100.00	18,784,261.85
159	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	9,466,500.00	14,961,169.50
160	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,366,600.00	3,648,432.92
161	Эрүүл мэндийн даатгалын хураамж	23,666,200.00	36,484,326.63
163	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,694,303.64	57,495,272.10
164	Гэрэл цахилгааны зардал	29,154,266.00	37,279,598.35
165	Түлш, халаалтын зардал	16,421,502.64	19,154,673.75
166	Цэвэр, бохир усны зардал	1,118,535.00	1,061,000.00
169	Хангамж, бараа материалын зардал	24,606,771.07	27,668,136.29
170	Бичиг хэргийн материал	918,815.98	1,749,900.00
171	Тээвэр, шатахууны зардал	13,193,278.00	12,062,388.00
172	Шуудан холбоо интернетийн төлбөр	3,344,220.00	5,446,105.00
174	Хог хаягдал устгах, цэвэрлэх	260,000.00	240,000.00
175	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,088,981.29	1,652,365.00
177	Бараа материал актасны зардал	5,801,475.80	6,517,378.29
180	Нормативт зардал	119,150.00	206,600.00
183	Нормын хувцас, зөөлөн эдлэл	119,150.00	206,600.00
184	Эд хогшил, урсгал засварын зардал	898,723.00	16,099,100.00
185	Багаж хэрэгсэл	718,433.00	1,046,309.00
188	Урсгал засвар	180,290.00	15,052,791.00
189	Томилолт, зочны зардал	1,160,000.00	4,672,000.00
191	Дотоод томилолтын зардал	1,160,000.00	4,672,000.00
193	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	30,903,749.35	20,459,944.75
194	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	26,350,671.35	16,459,599.75
195	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	604,800.00	1,008,000.00
196	Даатгалын үйлчилгээний төлбөр	303,800.00	152,450.00
197	Тээврийн хэрэгслийн татвар	182,400.00	58,900.00
198	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	22,000.00
199	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	484,000.00	649,000.00
200	Газрын төлбөр	2,890,078.00	2,109,995.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	47,354,411.26	48,437,180.42
209	Бараа үйлчилгээний бусад зардал	159,492.00	5,217,054.00
211	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,194,919.26	43,220,126.42
223	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,671,002.75	459,103,401.90
227	Бусад урсгал шилжүүлэг	90,648,300.00	246,012,306.00
233	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	90,648,300.00	246,012,306.00
236	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,702.75	213,091,095.90
239	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,702.75	213,091,095.90
267	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(11,103,208.28)	20,164,054.31
275	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	4,125,000.00	-
276	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,125,000.00	-
286	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(4,125,000.00)	-
287	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(15,228,208.28)	20,164,054.31

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр

код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,489,437,582.00	2,691,403,318.00
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	120,000.00	1,242,600.00
78	Нийтлэг татварын бус орлого	120,000.00	1,242,600.00
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	120,000.00	1,242,600.00
84	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,000.00	1,242,600.00
109	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,489,317,582.00	2,690,160,718.00
110	Улсын төвлөрсөн төсвөөс	1,481,559,800.00	2,687,466,818.00
111	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,481,559,800.00	2,687,466,818.00
120	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,757,782.00	2,693,900.00
124	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	4,679,032.00	-
125	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүр	3,078,750.00	2,693,900.00
145	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,489,425,582.00	2,691,403,318.00
146	УРСГАЛ ЗАРДАЛ	1,489,425,582.00	2,691,403,318.00
147	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,398,754,579.25	2,232,299,916.10
148	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,183,306,015.61	1,862,519,145.47
149	Үндсэн цалин	877,982,500.00	1,136,844,217.62
150	Нэмэгдэл	274,110,000.00	464,453,827.85
151	Унаа хоолны хөнгөлөлт	31,213,515.61	112,847,000.00
152	Үр дүнгийн урамшуулал	-	148,374,100.00
155	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	147,913,600.00	235,107,733.53
156	Тэтгэврийн даатгалын шимтгэл	100,581,200.00	161,229,542.63
157	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	11,833,100.00	18,784,261.85
158	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	9,466,500.00	14,961,169.50
159	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,366,600.00	3,648,432.92
160	Эрүүл мэндийн даатгалын хураамж	23,666,200.00	36,484,326.63
162	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	46,694,703.64	57,495,272.10
163	Гэрэл цахилгааны зардал	29,154,666.00	37,279,598.35
164	Түлш, халаалтын зардал	16,421,502.64	19,154,673.75
165	Цэвэр, бохир усны зардал	1,118,535.00	1,061,000.00
168	Хангамж, бараа материалын зардал	7,110,290.00	16,268,400.00
169	Бичиг хэрэг	707,600.00	1,729,900.00
170	Тээвэр, шатахуун	2,080,390.00	6,400,000.00
171	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,336,300.00	5,498,500.00
173	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, а	260,000.00	240,000.00
174	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	726,000.00	2,400,000.00
179	Нормативт зардал	332,000.00	980,000.00
182	Нормын хувцас, зөөлөн эдлэл	332,000.00	980,000.00
183	Эд хогшил, урсгал засварын зардал	1,395,100.00	36,227,766.00
184	Багаж техник хэрэгсэл	916,900.00	9,531,600.00
185	Тавилга	-	2,135,000.00
186	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	-	4,922,500.00
187	Урсгал засвар	478,200.00	19,638,666.00
188	Томилолт, зочны зардал	1,148,000.00	4,672,000.00
190	Дотоод албан томилолт	1,148,000.00	4,672,000.00
192	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	10,695,378.00	13,889,945.00
193	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчил	6,142,300.00	9,889,600.00
194	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	1,008,000.00
195	Даатгалын үйлчилгээ	303,800.00	152,450.00
196	Тээврийн хэрэгслийн татвар	182,400.00	58,900.00
197	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	22,000.00
198	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	484,000.00	649,000.00
199	Газрын төлбөр	2,890,078.00	2,109,995.00
206	Бараа үйлчилгээний бусад зардал	159,492.00	5,139,654.00
207	Бараа үйлчилгээний бусад зардал	159,492.00	5,139,654.00
219	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,671,002.75	459,103,401.90
223	Бусад урсгал шилжүүлэг	90,648,300.00	246,012,306.00
229	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэм	90,648,300.00	246,012,306.00
232	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,702.75	213,091,095.90
235	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,702.75	213,091,095.90
248	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	12,000.00	-
300	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	12,000.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр

код	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	
2	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	1,348,813,362.55	27,719,454.22	988,098,115.67	2,359,630,932.44
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,348,813,362.55	27,719,454.22	988,098,115.67	2,359,630,932.44
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.0	0	(15,228,208.28)	(15,228,208.28)
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,348,813,362.55	27,719,454.22	972,869,907.39	2,344,402,724.16
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,348,813,362.55	27,719,454.22	972,869,907.39	2,329,174,515.88
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,348,813,362.55	27,719,454.22	972,869,907.39	4,673,577,240.04
16	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0	0	20,164,054.31	20,164,054.31
17	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,348,813,362.55	27,719,454.22	993,033,961.70	2,664,566,778.47

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр

код	Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,695,384,100.00	2,475,618,322.10	219,765,777.90	91.8
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,695,384,100.00	2,475,618,322.10	219,765,777.90	91.8
4	зардал	2,440,841,100.00	2,229,606,016.10	211,235,083.90	91.3
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,047,514,600.00	1,862,519,145.47	184,995,454.53	91.0
6	Үндсэн цалин	1,227,671,400.00	1,136,844,217.62	90,827,182.38	92.6
7	Нэмэгдэл	558,622,100.00	464,453,827.85	94,168,272.15	83.1
8	олговор	112,847,000.00	112,847,000.00	-	100.0
9	Урамшуулал	148,374,100.00	148,374,100.00	(0.00)	100.0
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	255,939,800.00	235,107,733.53	20,832,066.47	91.9
12	Тэтгэврийн даатгал	174,038,800.00	161,229,542.63	12,809,257.37	92.6
13	Тэтгэмжийн даатгал	20,475,000.00	18,784,261.85	1,690,738.15	91.7
14	ҮОМШӨ ний даатгал	16,380,300.00	14,961,169.50	1,419,130.50	91.3
15	Ажилгүйдлийн даатгал	4,095,200.00	3,648,432.92	446,767.08	89.1
16	Эрүүл мэндийн даатгал	40,950,500.00	36,484,326.63	4,466,173.37	89.1
17	холбоотой тогтмол зардал	61,889,200.00	57,495,272.10	4,393,927.90	92.9
18	Гэрэл цахилгаан	41,452,300.00	37,279,598.35	4,172,701.65	89.9
19	Түлш, халаалт	19,375,900.00	19,154,673.75	221,226.25	98.9
20	Цэвэр, бохир ус	1,061,000.00	1,061,000.00	-	100.0
22	зардал	16,268,400.00	16,268,400.00	-	100.0
23	Бичиг хэрэг	1,729,900.00	1,729,900.00	-	100.0
24	Тээвэр (шатахуун)	6,400,000.00	6,400,000.00	-	100.0
25	интернэтийн төлбөр	5,498,500.00	5,498,500.00	-	100.0
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, Бага үнэтэй, түргэн	240,000.00	240,000.00	-	100.0
28	элэгдэх, аж ахуйн эд зүйлс	2,400,000.00	2,400,000.00	-	100.0
30	Нормативт зардал	980,000.00	980,000.00	-	100.0
33	Нормын хувцас зөөлөн эдлэл	980,000.00	980,000.00	-	100.0
34	Эд хогшил худалдан авах	33,686,600.00	33,533,866.00	152,734.00	99.5
35	Багаж, техник, хэрэгсэл	9,531,600.00	9,531,600.00	-	100.0
37	хэрэгсэл	5,005,000.00	4,922,500.00	82,500.00	98.4
38	Урсгал засвар	19,150,000.00	19,079,766.00	70,234.00	99.6
39	Томилолт, зочны зардал	4,856,000.00	4,672,000.00	184,000.00	96.2
41	Дотоод албан томилолт	4,856,000.00	4,672,000.00	184,000.00	96.2
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	14,495,500.00	13,889,945.00	605,555.00	95.8
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	9,894,500.00	9,889,600.00	4,900.00	100.0
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,008,000.00	1,008,000.00	-	100.0
46	Даатгалын үйлчилгээ	152,500.00	152,450.00	50.00	100.0
47	татвар	121,500.00	58,900.00	62,600.00	48.5
48	оношилгоо	88,000.00	22,000.00	66,000.00	25.0
49	зардал	649,000.00	649,000.00	-	100.0
50	Газрын төлбөр	2,582,000.00	2,109,995.00	472,005.00	81.7
53	зардал	5,211,000.00	5,139,654.00	71,346.00	98.6
54	зардал	5,211,000.00	5,139,654.00	71,346.00	98.6
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	254,543,000.00	246,012,306.00	8,530,694.00	96.6
70	Бусад урсгал шилжүүлэг	254,543,000.00	246,012,306.00	8,530,694.00	96.6
76	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн	254,543,000.00	246,012,306.00	8,530,694.00	96.6
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,695,334,100.00	2,686,015,518.00	9,318,582.00	99.7
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,695,234,100.00	2,687,466,818.00	7,767,282.00	99.7
99	Улсын төсвөөс санхүүжих ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН	2,695,234,100.00	2,687,466,818.00	7,767,282.00	99.7
110	ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	100,000.00	(1,451,300.00)	1,551,300.00	
112	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	(1,451,300.00)	1,551,300.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн үйл ажиллагааны зорилго нь: Тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд Ус, цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлыг батлагдсан хөтөлбөр заавар, журмын дагуу хийлгэх, ус цаг уур орчны зүй тогтол горимыг тогтоох, судалгаа шинжилгээ хийх дүгнэлт гаргах, ирээдүйн төлөв байдлын тухай мэдээллээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг хангахад чиглэгдэнэ. Тус байгууллага нь Байгаль орчин аялал жуулчлалын яамны харьяа байгууллага юм.

Ус, цаг, уур орчны шинжилгээний төв нь 2023 оны төлөвлөгөөг 1 зорилт 5 арга хэмжээтэй баталснаас нийт 94,2 хувьтай дүгнэгдсэн байна. Орон тоо 98 үүнээс захирал 1, гүйцэтгэх ажилтан 90, үйлчлэх ажилтан 7 бүгд 98 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол улсын 2023 оны төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

2023 онд тус байгууллага нь Аймгийн Засаг даргын нэрэмжит хяналт шалгалтад хамрагдсанаас гадна Байгаль, орчин аялал жуулчлалын яамнаас шалгалт хийгдэж 92,0 хувийн үр дүн үзүүлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд тусалцаа авах/ шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн* тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,164,0 мянган төгрөгөөр буюу 0,85 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ мян.төг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		5,000.0	5,000.0
Урьдчилгаа			
Бараа материал	1,045,646.9	1,088,141.1	42,494.2
Үндсэн хөрөнгө	1,298,755.9	1,276,420.7	(22,335.2)
Нийт хөрөнгө	2,344,402.7	2,364,566.8	20,164.0
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,344,402.7	2,364,566.8	20,164.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,344,402.7	2,364,566.8	20,164.0

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, авлага дансуудад өөрчлөлт гарсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 42,494.2 мянган төгрөгөөр өссөн нь ЦУОШГ-аас тусгай зориулалтын материал 41,895.1 мянган төгрөг, бусад хангамжийн материал 599.1 мянган төгрөгийн бараа материалыг тус тус шилжүүлэн авсан, мөн УЦУОШ-ний төвийн даргын 2023 оны 6 дугаар сарын 30-ний өдрийн А/12 тоот тушаалаар 524.6 мянган төгрөгийн, 2023 оны 5 дугаар сарын 16-ний өдрийн А/22 тоот тушаалаар 717.7 мянган төгрөг, 2023 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн А/39 тоот тушаалаар 5,488.2 мянган төгрөгийн нийт **6,730.5** мянган төгрөгийн бараа материалыг актлан устгасан зэрэг нөлөөллөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө 22,335.1 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвөөс 9,131.1 мянган төгрөгөөр барилгын их засвар хийж капиталжуулсан, Иж бүрэн компьютер 1 ш 4,100.0 мянган төгрөгөөр худалдан авсан, мөн 3,130.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, хөрөнгийн дахин үнэлгээгээр 10,015.0 мянган төгрөгөөр тус тус үндсэн хөрөнгө данс нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,475,600.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 100.0 мянган төгрөг, нийт зарлагыг 2,475,700.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 219,534.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, Төслийг 2,695,234.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2023 төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулсан гэж үзжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 2,695,234.1 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,695,234.1 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,475,618.3 мянган төгрөг буюу 91,8 хувьтай байгаа нь Цалин нэмэгдлийн зардлыг 184,995.4 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой зардлыг 4,393.9 мянган төгрөгөөр бусад зардлуудыг 30,226.5 мянган төгрөгөөр нийт **219,615.8** мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Дансны код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
80101	Үндсэн үйл ажиллагаа	2 436 576.6	2 225 341.5	211 235.1	91.3
80220	Холбооны сува ашиглалт	4,214.5	4,214.5		100%
80802	Тэтгэвэрт гарахад олгох 1 удаагийн мөнгөн тэтгэмж	254,443.0	246,062.3	8,380.7	96,6%
	Д Ү Н	2,695,234.1	2,475,618.3	219,615.8	91,8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн УЦУОШТөв нь 2023 онд нэмэгдэл төсөв байхгүй

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
	Арга хэмжээ 71408-80101	2023.01.02 2023.12.31	Үндсэн үйл ажиллагаа	Эрдэм шинжилгээ судалгааны ажил үйлчилгээ 91,34%тай	2 436 576.6	2 225 341.5
	Арга хэмжээ 71408-80220	2023.01.02 2023.12.31	Мэдээлэл солилцоо	Холбооны суваг ашигласны хөлс 100 %	4 214.5	4 214.5
	Арга хэмжээ 71408-80202	2023.01.02 2023.12.31	Тэтгэвэр гарахад олгох мөнгөн тэтгэмж	Эрдэм шинжилгээ судалгаан ажил үйлчилгээ	254 443.0	246 062.3

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөрийн шалтгаан нөхцөл байдлын талаар авч үзэхэд хүн тэтгэвэрт гарахад олгох мөнгөн тэтгэвэр хойшлуулсан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 43,700.0 мянган төгрөгийн цахилгаан дулаан, цэвэр бохир усны үйлчилгээг гэрээ шууд байгуулах аргаар, нийт 10,400.0 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 54,100.0 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хөрөнгийн анхан шатны бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Релаэнс секюритиз аудит ХХК-д 2023. оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 01/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,480,000,0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 29,600.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 23,680,0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэмнэж ажилласны үр дүнд ажиллагсад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 90,827.2 мянган төгрөгөөр
- Байр ашиглахтай холбоотой болон эд хогшил худалдан авах зардлыг 4,394.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “ Шилэн дансны цахим хуудасанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын “ заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 159 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож, 158 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна. Үүнд: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12 орлогын /тэтгэвэрт гарч буй иргэдтэй холбоотой/,12 зарлагын мөнгөн гүйлгээг хуулийн хугацаанд байршуулсан.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж үзлээ

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 1 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн аудитаар 1 зөвлөмж авсан. 100 хувь хэрэгжсэн.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/ мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	400.0	1	400,0	100%
Нийт дүн	1	400.0	1	400.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,984.7 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 10,984.7 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1.Их засвар хийсэн ажлын төсвийн гүйцэтгэлийг барилгын хувийн хэрэгт бичилт хийгдээгүй. Энэ нь Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 3 дугаар сарын 18-ны 71 тоот тушаалаар батлагдсан журмын 5-р заалт “Барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл шинэчлэл, их засварын хувийн хэрэг хөтлөх” заалтыг болон “Тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Запруулсан		Запруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны бүртгэлтэй холбоотой алдаа	1	10,984.7					1	10,984.7				
Дүн		10,984.7						10,984.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn